



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар

А/23

Улаанбаатар хот

### “Кес-Баскет” Олон Улсын тэмцээнд оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга Алтангэрэлийн Болдмааг Оросын Холбооны Улсын Пермь хотын ерөнхий боловсролын сурагчдын супер финалын тэмцээн зохион байгуулж буй арга туршлагыг судлах мөн 2017 оны 04 дүгээр сарын 19-нээс 24-ний өдрүүдэд зохиогдох “Кес-Баскет” Олон улсын тэмцээнд оролцох Монгол Улсын Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сагсан бөмбөгийн 28 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчдын ахлагчаар оролцуулахаар томилсугай.

2. Дээрх арга хэмжээнд оролцоход шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. А.Болдмаагийн холбогдох зардал болох 3.415.560 /гурван сая дөрвөн зуун арван таван мянган таван зуун жаран/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны сургалт семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээнд оролцох баг тамирчдын бэлтгэл сургуулилтыг сайтар хангаж зохион байгуулалтын өндөр хэмжээнд оролцуулж, тайлан мэдээг танилцуулан ажиллахыг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

115050005

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны  
даргын 2017 оны 04-р сарын 11-ны  
өдрийн 723 дугаар тушаалын хавсралт



Кес-Баскет Олон Улсын  
тэмцээнд оролцох зардал

| №        | Зардлын нэр                                                                                                  | Зардлын хэмжээ /төг/ |
|----------|--------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|
| 1.       | Онгоцны билетний зардал:<br>- Улаанбаатараас – Москва-Пермь<br>хүртэл<br>- Пермь-Москва-Улаанбаатар хүртэл   | 2.000.000 ₮          |
| 2.       | Томилолт 2 өдөр 210\$ = 420\$<br>420\$ x 2418₮ = 1.015.560₮                                                  | 1.015.560₮           |
| 3.       | “Кес-Баскет” төрийн бус байгууллагын 10<br>жилийн ойд зориулсан бэлэг дурсгалын зүйл<br>худалдаж авах зардал | 400.000₮             |
| НИЙТ ДҮН |                                                                                                              | 3.415.560₮           |

Боловсруулсан:

Нийслэлийн Нийтийн биеийн тамир,  
спортын хорооны мэргэжилтэн

Б.Түвшинбаяр

Хянасан:

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир,  
спортын хорооны нягтлан бодогч

О.Эрдэнэцэцэг